



Н.П.ШАСТИНЫ НЭРЭМЖИТ УЛСЫН
ГУРАВДУГААР ТӨВ ЭМНЭЛГИЙН ДАРГА
Ц.ТӨМӨР-ОЧИР ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.02.24 № 3/375

танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Н.П.Шастины нэрэмжит улсын гуравдугаар төв эмнэлгийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

Н.П.Шастины нэрэмжит улсын гуравдугаар төв эмнэлгийн удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем, тэгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Н.П.Шастины нэрэмжит улсын гуравдугаар төв эмнэлгийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

8\10.10.10.20\Bichig_Kheregi\Yawsan_Bichig\2017\02\24\SAG60.docx

070545

**П.Н.ШАСТИНЫ НЭРЭМЖИТ УЛСЫН
ГУРАВДУГААР ТӨВ ЭМНЭЛГИЙН
2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

Захиалагч:

ТАБ-ын Тэргүүлэх аудитор: С.Энхзаяа
Утас: 261663
Цахим хаяг:
enkzayas@audit.gov.mn

Аудитын менежер:
Н.Золзаяа
Утас: 315558
Цахим хаяг:
zolzayan@audit.gov.mn

Аудитор:
Ж.Болормаа
Утас: 260512
Цахим хаяг:
bolormaaj@audit.gov.mn

ТАБ-ын хаяг: Үндэсний аудитын
газар

Байршил: Чингэлтэй дүүрэг
Цахим хуудас: www.audit.mn

Аудитийг гэрээгээр гүйцэтгэгч:

Аяа такс аудит ХХК-ний
Ерөнхий захирал

Я.Аюушжав
Утас: 99994447
Цахим хаяг: Ayaa_ayaab@yahoo.com

Аудитор:
Ц.Хишигзаяа
Утас: 99087133

Хаяг: УБ хот, ЧД 1-р хороо, Рааш булаг
ХХК 402 тоот

Аудитын тайлан

- | | |
|-------------|-----------------------------------|
| Хавсралт 1: | Агуулга |
| Хавсралт 2: | Аудитын гэрчилгээ |
| Хавсралт 3: | Менежментийн захидал |
| Хавсралт 4: | Аудит хийсэн санхүүгийн
тайлан |
| Хавсралт 5: | Төсвийн гүйцэтгэлийн
тайлан |

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Зөвлөмж
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Нэг. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйл 8.9.1 “Төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх”, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1 “Улсын Их Хурлаас бусад төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд санхүүжилтийн эх үүсвэрээс нь үл хамааран аудит хийх. Улсын Их Хурлын зөвхөн санхүүгийн тайланд аудит хийх бөгөөд хэрэв Улсын Их Хурлаас хүссэн тохиолдолд бусад үйл ажиллагаанд нь аудит хийх”, дэхь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлд 18.2 “Төрийн аудитын байгууллага Төсвийн тухай хуулиар тогтоосон хугацаанд санхүүгийн тайланд аудит хийж дүгнэлт гарган төсвийн ерөнхийлөн захирагчид, дүгнэлтийн хувийг шаардлагатай гэж үзвэл санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллагад тус тус хүргүүлнэ” заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд П.Н.Шастины нэрэмжит улсын гуравдугаар төв эмнэлгийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /ҮАГ-САГ/2016/17/СТА-ТШЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

П.Н.Шастины нэрэмжит улсын гуравдугаар төв эмнэлгийн 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

П.Н.Шастины нэрэмжит улсын гуравдугаар төв эмнэлгийн 2016 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2016 оны 9 дүгээр сарын 15 өдрөөс 2016 оны 2 дугаар сарын 14-ны хооронд хийхээр төлөвлөн Аяа Такс Аудит ХХК-ийн аудитор Ц.Хишигзаяа хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

П.Н.Шастины нэрэмжит улсын гуравдугаар төв эмнэлгийн 2016 оны санхүүгийн тайланг 2017 оны 1 дүгээр сарын 22-нд Аяа такс Аудит ХХК-д ирүүлсэн байна.

Аяа такс Аудит ХХК аудитыг 2017 оны 1 дугаар сарын 22-ноос 2017 оны 2 дугаар сарын 21-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг Төсвийн тухай хуульд заасан хугацаанд П.Н.Шастины нэрэмжит улсын гуравдугаар төв эмнэлгийн дарга Ц.Төмөр-Очирт гардуулна.

Хоёр. Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

П.Н.Шастины нэрэмжит улсын гуравдугаар төв эмнэлэг “Эрүүл мэндийн тухай” хууль, Төсвийн тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай”, “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд “Эрүүл мэндийн байгууллагын тогтолцоо нь нийгмийн эрүүл мэндийн, эмнэлгийн тусламж, үйлчилгээний, эм хангамжийн, анагаах ухааны боловсрол, эрдэм шинжилгээ, сургалтын үйл ажиллагаа хариуцсан төрийн, хувийн хэвшлийн, холимог өмчийн эрүүл мэндийн байгууллагаас бүрдэнэ” гэж эрүүл мэндийн байгууллагын тогтолцоог тодорхойлсны дагуу П.Н.Шастины нэрэмжит улсын гуравдугаар төв эмнэлэг үйл ажиллагаагаа явуулж байна.

Гурав. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Шударга өрсөлдөөн, сонголтонд суурилсан, аюулгүй, чанартай эрүүл мэндийн оношилгоо, эмчилгээ, үйлчилгээ авах боломжийг иргэн бүрт олгох олон улсын стандартад нийцсэн нөхцлийг бүрдүүлэх явдал мөн гэж эрүүл мэндийн байгууллагын зорилтыг тодорхойлсон байна.

П.Н.Шастины нэрэмжит улсын гуравдугаар төв эмнэлгийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Дөрөв. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар П.Н.Шастины нэрэмжит улсын гуравдугаар төв эмнэлгийн 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 12-г гүйцэтгэв.

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад П.Н.Шастины нэрэмжит улсын гуравдугаар төв эмнэлгийн санхүүгийн САГ-2017/286/СТА-ТШЗ

үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан тус эмнэлгийн даргын 170 дугаар тушаалаар батлуулан 2015 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн мөрдөн ажиллаж байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь УСНББОУС-тай нийцсэн байна. ОУ-ын стандарттай нийцсэн бүртгэлийн бодлоготой, нягтлан бодох бүртгэлийн програм нийцсэн байна.

П.Н.Шастины нэрэмжит улсын гуравдугаар төв эмнэлгийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

П.Н.Шастины нэрэмжит улсын гуравдугаар төв эмнэлгийн төлөвлөлт болон гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 2016 оны төсвийн зарлагыг материаллаг байдлын суурь болгон авч 1 хувиар сонгон 290.6 сая төгрөгөөр тогтоов. /ТАБ-СТА-А-4/, /ТАБ-СТА-В-1 /

П.Н.Шастины нэрэмжит улсын гуравдугаар төв эмнэлгийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн Acolous програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Тав. Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр хянасан.

2016 онд тус эмнэлэг нь “Харилцааны соёлын жил” болгосон бөгөөд дотоод хяналтын хүрээнд дараах ажлуудыг хийсэн байна. Үүнд:

Аудитаар төслөөр нийлүүлэгдсэн зарим тоног төхөөрөмжүүдийн ашиглалт, урвалж, оношлуур, дүрс оношлогооны тусламж үйлчилгээний орлогын гүйцэтгэл зэрэгт шалгалт хийж төлбөрт үйлчилгээнээс орох орлогын гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах, урвалж болон дүрс оношлогоонд хэрэглэгдэж байгаа урвалж, пленкийн зарцуулалтад нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт хөтлөх үүргийг өгсөн байна.

Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. П.Н.Шастины нэрэмжит улсын гуравдугаар төв эмнэлгийн дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Зургаа. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

2016 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу П.Н.Шастины нэрэмжит улсын гуравдугаар төв эмнэлэг хуваарилан авч, тус эмнэлгийн үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтэц, үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлж, хэрэгжүүлэн ажилласан байна.

П.Н.Шастины нэрэмжит улсын гуравдугаар төв эмнэлэг 2016 онд улсын төсвөөс 4,894.3 сая төгрөгийн санхүүжилт авч үүнээс энэ хэмжээгээр урсгал зардалд зарцуулж, оны эцэст төгрөгийн үлдэгдэлгүй гарсан байна.

Тайлант хугацаанд 4,894.3 сая төгрөгийн санхүүжилт авч, 3,151.6 сая төгрөгийн үндсэн үйл ажиллагааны, 1582.2 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт, 167.5 сая төгрөгийн үндсэн бус үйл ажиллагааны орлого олж, Нийгмийн даатгалийн санхүүжилт 15,919.1 сая төгрөгийн, үнэ төлбөргүй эмийн орлогоор 87.9 сая төгрөгийн нийт 27,062.0 сая төгрөгийн орлогын эх үүсвэртэй ажилласан байна. Тайлант хугацааны эцэст улсын төсөвт 9.5 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

П.Н.Шастины нэрэмжит улсын гуравдугаар төв эмнэлэг нь тайлант онд 29,066.5 сая төгрөг зардал гаргасаны 13,527.3 сая төгрөг буюу 47% эм бэлдмэл эмнэлгийн хэрэгсэлд, 9,058.5 сая төгрөг буюу 31% цалин түүнтэй адилтгах зардал, 6,480.7 сая төгрөг буюу 22% нь бусад зардал байна.

Долоо. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн болон улс, орон нутгийн хөрөнгийн үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа, ил тод нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих.

Найм. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Төлөвлөлтийн үе шатанд аудитын 3 чиглэлээр 39 эрсдэлүүдийг тогтоон, түүнд тавигдах хяналтуудыг үнэлэхэд үр нөлөөтэй байгаа тул нарийвчилсан сорилын аргаар даган мөшгих сорилыг хийлээ.

Санхүүгийн аудитыг төлөвлөлтийн үе шатыг 11, гүйцэтгэлийн үе шатыг 9, тайнагналын үе шатыг 3 ажилбараар тус тус харуулав.

Үйлчлүүлэгчээс авсан судалгаа, тоон мэдээлэл, тайлбар, тодорхойлолт, нотлох баримтууд болон өөрсдийн хийсэн судалгаануудыг байгууллагын хард дискэнд хадгалав.

Ес. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

П.Н.Шастины нэрэмжит улсын гуравдугаар төв эмнэлгийн 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, бусад орлого, бичиг хэрэг, тээвэр шатахуун, шуудан холбоо, төлбөр хураамж, сургалт семинар зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Арав. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв.

Аудитын явцад материаллаг хэмжээний алдаа илрээгүй бөгөөд материаллаг бус дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

1. Тайлант оны төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 140.6 сая төгрөгийн зардлыг хэмнэсэн боловч бичиг хэрэг, шуудан холбоо, интернетийн төлбөр, хог, хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал, хоол хүнс, хөдөлмөр хамгааллын хэрэгсэл, урсгал засварын зардал зэргийг 22.8 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-ыг мөрдөж ажиллах талаар зөвлөмж өгөв.

2. Өндөр өртөгтэй тусламж үйлчилгээний анхан шатны баримтыг санхүүгийн програмтай уялдуулан холбож, түүнд тавих хяналтыг сайжруулах.

Шийдвэрлэсэн: Эмнэлгийн хэмжээнд нэг цэгийн үйлчилгээний программыг шинэчлэж байгаа бөгөөд үүнээс өндөр өртөгтэй эм хангамжийн зарцуулалт, хяналт сайжрах юм.

Арван нэг. Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Аудитын явцад илэрсэн материаллаг бус 22.8 сая төгрөгийн алдааг залруулах боломжгүй байна.

Арван хоёр. Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

Арван гурав. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Тус эмнэлгийн 2016 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

Арван дөрөв. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

П.Н.Шастины нэрэмжит улсын гуравдугаар төв эмнэлгийн 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 22.8 сая төгрөгийн зөрчлийг арилгах талаар санхүүгийн тайланд зөвлөмж өглөө.

Арван тав. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

П.Н.Шастины нэрэмжит улсын гуравдугаар төв эмнэлгийн 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд 2 зөвлөмж өгсөний хэрэгжилтийн явц 70.0 хувьтай байна.

Арван зургаа. Зөвлөмж

П.Н.Шастины нэрэмжит улсын гуравдугаар төв эмнэлгийн төсвийн 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар 2 зөвлөмж өгөв.

Арван долоо. Зөрчилгүй санал дүгнэлт:

П.Н.Шастины нэрэмжит улсын гуравдугаар төв эмнэлгийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн, шударга илэрхийлэгдсэн байна.

**П.Н.ШАСТИНЫ НЭРЭМЖИТ
УЛСЫН ГУРАВДУГААР ТӨВ
ЭМНЭЛГИЙН 2016 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдох № 1 зүйлс

Асуудал 1:

**Өндөр өртөгтэй тусламж
үйлчилгээний зардлыг бүртгэх**

Асуудал 2:

Зардал

2016 оны 2 дугаар сар 17 өдөр

Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Төсвийн шууд захирагчид зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Төсвийн захирагчийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**Асуудал 1: Өндөр өртөгтэй
тусламж үйлчилгээний зардлыг
бүртгэх**

Тэргүүлэх ач холбогдол № 1

Аудитын ажиглалт

Өндөр өртөгтэй тусламж үйлчилгээний анхан шатны баримтыг санхүүгийн програмтай уялдуулан холбож шалгахад бэлтгэн нийлүүлэгчид болон үйлчлүүлэгчдийн нэрсийг нэг бүлэг үзүүлэлтээр тайлагнаж байна.

Аудитын зөвлөмж

Бэлтгэн нийлүүлэгчид болон үйлчлүүлэгчдийн нэрсийг бүлгээр кодолж тайлагнах, түүнд тавих хяналтыг сайжруулах.

Эрсдэлүүд

Хяналт шалгалтын ажлыг хүндрүүлэх,
үргүй цаг зарцуулах

Үйлчлүүлэгчийн хариу

Эмнэлгийн хэмжээнд нэг цэгийн үйлчилгээний программыг шинэчлэж байгаа бөгөөд үүнээс өндөр өртөгтэй эм хангамжийн зарцуулалт, хяналт сайжрах юм.

Асуудал 2: Зардал

Тэргүүлэх ач холбогдол № 2

Аудитын ажиглалт

-Тайлант оны төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 140.6 сая төгрөгийн зардлыг хэмнэсэн боловч бичиг хэрэг, шуудан холбоо, интернетийн төлбөр, хог, хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал, хоол хүнс, хөдөлмөр хамгааллын хэрэгсэл, урсгал засварын зардал зэргийг 22.8 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Аудитын зөвлөмж

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-ыг мөрдөж ажиллах.

Үйлчлүүлэгчийн хариу

зөвшөөрсөн

Эрсдэлүүд

Зардлыг зориулалтын дагуу зарцуулаагүй, хяналт сул байгаагаас үргүй зардал гарах.

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

төгрөгөөр

Мөрийн дугаар	Балансын зүйл	Үлдэгдэл	
		1 сарын 1	12 сарын 31
I	ЭРГЭЛТИЙН ХӨӨНГИЙН ДҮН	1 680 271 297,10	2 104 416 236,04
33	АВЛАГА	4 882 599,99	0,00
33300	Татаас,санхүүжилтийн авлага	4 882 599,99	0,00
35	БАРАА МАТЕРИАЛ	1 675 388 697,11	2 104 416 236,04
35100	Түүхий эд материал	1 672 616 452,11	2 099 380 420,84
35110	Тусгай зориулалттай материал	1 393 563 715,39	1 668 452 303,86
35130	Эм,боох материал	279 052 736,72	430 928 116,98
35400	Хангамжийн материал	2 772 245,00	5 035 815,20
35410	Бичиг хэргийн материал	1 607 800,00	444 805,00
35430	Сэлбэг хэрэгсэл	0,00	108 000,00
35440	Түлш,шатах тослох материал	607 531,00	514 625,20
35460	Хүнсний материал	556 914,00	3 968 385,00
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨӨНГИЙН ДҮН	35 872 647 356,74	33 446 908 881,01
39	ҮНДСЭН ХӨӨНГӨ	35 872 647 356,74	33 446 908 881,01
39200	Биет хөрөнгө	35 824 595 377,55	33 406 769 297,64
39201	Барилга,байгууламж,орон сууц	30 536 247 696,55	31 245 055 051,55
39202	Хуримтлагдсан элэгдэл	14 044 498 581,75	14 684 172 795,26
39203	Авто-тээврийн хэрэгсэл	227 295 750,00	227 295 750,00
39204	Хуримтлагдсан элэгдэл	129 866 865,97	164 320 166,95
39205	Машин,тоног төхөөрөмж (компьютер)	24 864 229 780,76	25 996 999 074,11
39206	Хуримтлагдсан элэгдэл	6 890 635 369,31	10 158 779 386,16
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	1 748 656 145,36	1 756 246 145,36
39208	Хуримтлагдсан элэгдэл	486 833 178,09	811 554 375,01
39300	Биет бус хөрөнгө	48 051 979,19	40 139 583,37
39301	Програм хангамж	349 293 470,00	353 093 470,00
39302	Хуримтлагдсан элэгдэл	301 241 490,81	312 953 886,63
III	НИЙТ ХӨӨНГИЙН ДҮН	37 552 918 653,84	35 551 325 117,05
V	ЦЭВЭР ХӨӨНГӨӨМЧИЙН ДҮН	37 552 918 653,84	35 551 325 117,05
51	Засгийн газрын хувь оролцоо	15 283 949 417,50	15 283 949 417,50
51100	Засгийн газрын оруулсан капитал	15 283 949 417,50	15 283 949 417,50
51200	Хуримтлагдсан үр дүн	11 625 668 538,18	9 624 075 001,39
51210	Өмнөх үеийн үр дүн	11 625 668 538,18	11 625 668 538,18
51220	Тайлант үеийн үр дүн	0,00	-2 001 593 536,79
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	10 643 300 698,16	10 643 300 698,16
VIII	НИЙТ Ө ТӨЛБӨР ЦЭВЭР ХӨӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	37 552 918 653,84	35 551 325 117,05

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Дансны код	Балансын зүйл	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	20 483 022 701,54	27 062 050 197,81
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2 092 892 911,00	3 407 074 703,97
120	Нийтлэг татварын бус орлого	1 834 881 445,00	3 319 128 224,90
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1 834 881 445,00	3 319 128 224,90
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1 675 382 745,00	3 151 644 224,90
1200042	Түслэх үйл ажиллагааны орлогоос санхүүжих	159 498 700,00	167 484 000,00
122	Тусламжийн орлого	258 011 466,00	87 946 479,07
122001	Хандив тусламж /дотоод	258 011 466,00	87 946 479,07
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	18 390 129 790,54	23 654 975 493,84
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	8 347 060 501,55	6 476 506 102,35
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4 725 822 740,00	4 894 265 500,00
131005	Хөрөнгийн санхүүжилт	3 621 237 761,55	1 582 240 602,35
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	128 558 349,99	1 259 380 851,49
131104	Нэмэлт санхүүжилт	128 558 349,99	1 259 380 851,49
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	9 914 510 939,00	15 919 088 540,00
134003	Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт	9 914 510 939,00	15 919 088 540,00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	20 417 448 438,37	29 063 309 227,09
21	УРСГАЛ ЗАРДАЛ	20 417 448 438,37	29 063 309 227,09
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	20 311 784 394,91	28 716 006 727,06
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	7 744 780 782,84	7 848 049 237,57
210101	Үндсэн цалин	7 184 211 684,95	7 200 697 691,23
210103	Унаа хоолны хөнгөлөлт	551 013 901,72	647 351 546,34
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	856 002 644,38	871 204 306,80
210201	Тэтгэврийн даатгал	699 912 155,82	560 966 669,73
210202	Тэтгэмжийн даатгал	31 703 332,59	63 626 781,47
210203	ҮОМШӨний даатгал	39 210 606,92	78 199 080,12
210204	Ажилгүйдлийн даатгал	7 724 283,97	15 281 314,52
210205	Эрүүл мэндийн даатгал	77 452 265,08	153 130 460,96
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	566 261 848,99	689 022 313,01
210301	Гэрэл, цахилгаан	300 013 915,00	348 677 694,00
210302	Түлш, халаалт	177 100 643,00	214 156 769,00
210303	Цэвэр, бохир ус	89 147 290,99	126 187 850,01
2104	Хангамж, бараа материалын зардал	462 099 308,82	297 709 055,46
210401	Бичиг хэрэг	98 251 124,00	61 690 585,00

210402	Тээвэр, шатахуун	61 946 245,00	31 095 515,80
210403	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	20 791 773,62	24 034 186,23
210404	Ном, хэвлэл	14 515 787,00	11 609 295,00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	63 871 700,00	56 582 998,00
210408	Бараа материал акталсны зардал	202 722 679,20	112 696 475,43
2105	Нормативт зардал	6 209 095 871,53	13 209 019 131,17
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5 744 702 485,53	12 742 130 176,17
210502	Хоол, хүнс	431 099 186,00	427 895 299,00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	33 294 200,00	38 993 656,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	321 613 181,80	887 796 236,00
210601	Багаж, техник, хэрэгсэл	19 621 144,00	102 750 275,00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	128 733 890,00	93 032 335,00
210604	Урсгал засвар	173 258 147,80	692 013 626,00
2107	Томилолт, зочны зардал	38 713 474,00	77 365 300,00
210701	Гадаад албан томилолт	32 548 490,00	70 028 000,00
210702	Дотоод албан томилолт	5 557 834,00	7 337 300,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12 166 400,00	35 641 319,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5 940 000,00	24 000 000,00
210803	Даатгалын үйлчилгээ	327 500,00	350 000,00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	378 675,00	400 000,00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	213 215,00	85 000,00
210807	Газрын төлбөр	3 937 100,00	10 531 819,00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	24 010,00	274 500,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4 101 050 882,55	4 800 199 828,05
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13 552 058,00	100 065 014,00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11 406 400,00	95 904 243,48
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	4 076 092 424,55	4 604 230 570,57
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	105 664 043,46	347 302 500,03
2132	Бусад урсгал шилжүүлэг	96 119 232,00	336 098 500,00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	74 717 832,00	334 298 500,00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	18 366 400,00	1 800 000,00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	9 544 811,46	11 204 000,03
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	9 544 811,46	11 204 000,03
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	65 574 263,17	-2 001 259 029,28
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	96 500 246,88	334 507,51
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	96 500 246,88	334 507,51
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	-30 925 983,71	-2 001 593 536,79

АУДИТ ХИЙСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН.

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2014 оын 12 сарын 31-ээр үлдэгдэл				
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
Тайлангийн үеийн үр дүн				
2015 оын 12 сарын 31-ээр үлдэгдэл	15 283 949 417,50	10 643 300 698,16	11 625 668 538,18	37 552 918 653,84
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
Тайлангийн үеийн үр дүн			-2 001 593 536,79	-2 001 593 536,79
2016 оын 12 сарын 31-р үлдэгдэл	15 283 949 417,50	10 643 300 698,16	9 624 075 001,39	35 551 325 117,05

АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/төгрөгөөр/

Дансны дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	16 602 620 313,99	25 379 492 036,38
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1 839 355 885,00	3 301 953 144,90
120	Нийтлэг татварын бус орлого	1 839 355 885,00	3 301 953 144,90
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1 839 355 885,00	3 301 953 144,90
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1 651 823 116,00	3 151 909 144,90
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	187 532 769,00	150 044 000,00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	14 763 264 428,99	22 077 538 891,48
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	4 725 822 740,00	4 894 265 500,00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4 725 822 740,00	4 894 265 500,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	122 930 749,99	1 264 184 851,48
131104	Нэмэлт санхүүжилт	122 930 749,99	1 264 184 851,48
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	9 914 510 939,00	15 919 088 540,00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	9 914 510 939,00	15 919 088 540,00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	16 534 116 513,99	25 236 197 036,38
21	УРСГАЛ ЗАРДАЛ	16 534 116 513,99	25 236 197 036,38
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	16 433 694 479,53	24 888 894 536,35
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	7 747 946 567,22	7 855 315 209,37
210101	Үндсэн цалин	6 609 859 968,06	6 709 981 438,44
210103	Унаа хоолны хөнгөлөлт	663 790 599,32	663 790 600,00
210104	Урамшуулал	474 295 999,84	481 543 170,93
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	852 274 900,00	864 203 255,00
210201	Тэтгэврийн даатгал	852 274 900,00	864 203 255,00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	566 261 848,99	689 022 313,01
210301	Гэрэл, цахилгаан	300 013 915,00	348 677 694,00
10302	Түлш, халаалт	177 100 643,00	214 156 769,00
210303	Цэвэр, бохир ус	89 147 290,99	126 187 850,01
2104	Хангамж, бараа материалын зардал	216 523 377,62	154 299 386,23
210401	Бичиг хэрэг	48 618 390,00	18 641 582,00
210402	Тээвэр, шатахуун	28 026 601,00	30 787 200,00
210403	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	14 626 483,62	24 151 886,23
210404	Ном, хэвлэл	8 141 303,00	2 860 000,00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	82 451 200,00	49 709 938,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	34 659 400,00	28 148 780,00
2105	Нормативт зардал	4 445 822 300,00	4 906 477 057,26
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3 899 908 300,00	4 372 061 587,26
210502	Хоол, хүнс	431 145 000,00	431 306 770,00

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	114 769 000,00	103 108 700,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	303 605 382,70	1 346 757 099,00
210601	Багаж, техник, хэрэгсэл	83 654 382,70	182 763 010,00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	57 899 800,00	73 443 760,00
210604	Урсгал засвар	159 051 200,00	1 090 550 329,00
2107	Томилолт, зочны зардал	38 106 324,00	77 365 300,00
210701	Гадаад албан томилолт	32 548 490,00	70 028 000,00
210702	Дотоод албан томилолт	5 557 834,00	7 337 300,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	40 364 482,00	168 620 800,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	30 497 497,00	139 320 000,00
210803	Даатгалын үйлчилгээ	327 500,00	350 000,00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	378 675,00	400 000,00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	85 000,00	85 000,00
210807	Газрын төлбөр	3 937 100,00	4 948 200,00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	24 010,00	4 140 000,00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	0,00	19 377 600,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2 222 789 297,00	8 826 834 116,48
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2 211 382 897,00	8 725 770 717,00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11 406 400,00	101 063 399,48
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	100 422 034,46	347 302 500,03
2132	Бусад урсгал шилжүүлэг	90 877 223,00	336 098 500,00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	69 225 823,00	334 298 500,00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10 666 400,00	1 800 000,00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	9 544 811,46	11 204 000,03
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	9 544 811,46	11 204 000,03
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	68 503 800,00	143 295 000,00
V	ХӨӨНГӨОРОУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	68 503 800,00	143 295 000,00
22	ХӨӨНГИЙН ЗАРДАЛ	68 503 800,00	143 295 000,00
2200	Дотоод эх үүсвэрээр	68 503 800,00	143 295 000,00
222001	Тавилга эд хогшил	13 948 800,00	7 590 000,00
222002	Техник хэрэгсэл, багаж тоног төхөөрөмж	22 955 000,00	131 905 000,00
222004	Програм хангамж	31 600 000,00	3 800 000,00
VI	ХӨӨНГӨОРОУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-68 503 800,00	-143 295 000,00

АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН.

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	25 522 636 092,00	25 379 492 036,38	143 144 055,62	99%
НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	25 522 636 092,00	25 379 492 036,38	143 144 055,62	99%
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	25 177 362 592,00	24 888 894 536,35	288 468 055,65	99%
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	16 457 844 121,00	16 169 376 071,98	288 468 049,02	98%
Цалин хөлс болон нэмэгдэл суутгал	7 855 315 216,00	7 855 315 209,37	6,63	100%
Үндсэн цалин	6 717 228 616,00	6 709 981 438,44	7 247 177,56	100%
Унаа хоолны нэмэгдэл	663 790 600,00	663 790 600,00	0,00	100%
Урамшуулал	474 296 000,00	481 543 170,93	-7 247 170,93	102%
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	864 203 255,00	864 203 255,00	0,00	100%
Тэтгэврийн даатгал	551 699 255,00	864 203 255,00	-312 504 000,00	157%
Тэтгэмжийн даатгал	62 500 800,00	0,00	62 500 800,00	0%
ҮОМШӨний даатгал	78 126 000,00	0,00	78 126 000,00	0%
Ажилгүйдлийн даатгал	15 625 200,00	0,00	15 625 200,00	0%
Эрүүл мэндийн даатгал	156 252 000,00	0,00	156 252 000,00	0%
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	780 294 600,00	689 022 313,01	91 272 286,99	88%
Гэрэл, цахилгаан	371 722 000,00	348 677 694,00	23 044 306,00	94%
Түлш, халаалт	273 180 800,00	214 156 769,00	59 024 031,00	78%
Цэвэр, бохир ус	135 391 800,00	126 187 850,01	9 203 949,99	93%
Хангамж, бараа материалын зардал	154 303 900,00	154 299 386,23	4 513,77	100%
Бичиг хэрэг	17 749 000,00	18 641 582,00	-892 582,00	105%
Тээвэр, шатахуун	33 455 900,00	30 787 200,00	2 668 700,00	92%
Шуудан,холбоо, интернетийн төлбөр	20 043 000,00	24 151 886,23	-4 108 886,23	121%
Ном, хэвлэл	2 860 000,00	2 860 000,00	0,00	100%
Хог,хаягдал зайлуулах,хортон мэрэгчдийн устгал,ариутгал	47 683 500,00	49 709 938,00	-2 026 438,00	104%
БҮТЭЗҮйлс	32 512 500,00	28 148 780,00	4 363 720,00	87%
Нормативт зардал	4 921 357 100,00	4 906 477 057,26	14 880 042,74	100%
Эм,бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4 397 102 100,00	4 372 061 587,26	25 040 512,74	99%
Хоол хүнс	421 145 000,00	431 306 770,00	-10 161 770,00	102%
Нормын хувцас, зөөлөн эдлэл	103 110 000,00	103 108 700,00	1 300,00	100%
Эд хогшил, урсгал засварын зардал	1 393 111 899,00	1 346 757 099,00	46 354 800,00	97%
Багаж,техник хэрэгсэл	234 819 000,00	182 763 010,00	52 055 990,00	78%
Хөдөлмөр хамгааллын	73 285 600,00	73 443 760,00	-158 160,00	100%

хэрэгсэл				
Урсгал засвар	1 085 007 299,00	1 090 550 329,00	-5 543 030,00	101%
Томилолт, зочны зардал	77 365 300,00	77 365 300,00	0,00	100%
Гадаад албан томилолт	70 028 000,00	70 028 000,00	0,00	100%
Дотоод албан томилолт	7 337 300,00	7 337 300,00	0,00	100%
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	183 300 800,00	168 620 800,00	14 680 000,00	92%
Бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	154 000 000,00	139 320 000,00	14 680 000,00	90%
Даатгалын үйлчилгээ	350 000,00	350 000,00	0,00	100%
Тээврийн хэрэгслийн татвар	400 000,00	400 000,00	0,00	100%
Тээврийн хэрэгслийн оношлогоо	85 000,00	85 000,00	0,00	100%
Газрын төлбөр	4 948 200,00	4 948 200,00	0,00	100%
Банк,санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	4 140 000,00	4 140 000,00	0,00	100%
Улсын мэдээллийн маягт хэвлэх,бэлтгэх	19 377 600,00	19 377 600,00	0,00	100%
Бараа үйлчилгээний бусад зардал	8 948 110 522,00	8 826 834 116,48	121 276 405,52	99%
Бараа үйлчилгээний бусад зардал	8 846 878 122,00	8 725 770 717,00	121 107 405,00	99%
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	101 232 400,00	101 063 399,48	169 000,52	100%
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	336 098 500,00	347 302 500,03	-11 204 000,03	103%
Бусад урсгал шилжүүлэг	336 098 500,00	336 098 500,00	0,00	100%
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	334 298 500,00	334 298 500,00	0,00	100%
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1 800 000,00	1 800 000,00	0,00	100%
Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт,шилжүүлэг	0,00	11 204 000,03	-11 204 000,03	0%
Төвлөрүүлэх шилжүүлэг	0,00	11 204 000,03	-11 204 000,03	0%
ХӨӨНГӨОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДАЛ	9 175 000,00	143 295 000,00	-134 120 000,00	1562%
Дотоод эх үүсвэрээр	9 175 000,00	143 295 000,00	-134 120 000,00	1562%
Тавилга эд хогшил	0,00	7 590 000,00	-7 590 000,00	0%
Техник хэрэгсэл,багаж тоног төхөөрөмж	9 175 000,00	131 905 000,00	-122 730 000,00	1438%
Програм хангамж	0,00	3 800 000,00	-3 800 000,00	0%
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	25 522 636 092,00	25 379 492 036,38	143 144 055,62	99%
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО	3 296 939 700,00	3 151 909 144,90	145 030 555,10	96%
Үндсэн үйл ажиллагааны орлого	3 296 939 700,00	3 151 909 144,90	145 030 555,10	96%
ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО	150 044 000,00	150 044 000,00	0,00	100%
Үндсэн бус үйл ажиллагааны	150 044 000,00	150 044 000,00	0,00	100%

орлого				
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	6 156 563 852,00	6 158 450 351,48	-1 886 499,48	100%
Улсын төсвөөс санхүүжих	4 894 265 500,00	4 894 265 500,00	0,00	100%
Нэмэлт санхүүжилтийн орлого	1 262 298 352,00	1 264 184 851,48	-1 886 499,48	100%
Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	15 919 088 540,00	15 919 088 540,00	0,00	100%
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	15 919 088 540,00	15 919 088 540,00	0,00	100%